



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/380

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн гэрэлтүүлэг (Сайхан сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан "Спейшлтим ап" ХХК-тай 165,022,812 (нэг зуун жаран таван сая хорин хоёр мянга найман зуун арван хоёр) төгрөгөөр, үүнээс аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас 123,767,109 (нэг зуун хорин гурван сая долоон зуун жаран долоон мянга нэг зуун ес), сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас 41,255,703 (дөчин нэгэн сая хоёр зуун тавин таван мянга долоон зуун гурван мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Спейшлтим ап" ХХК-ийн захирал (Д.Номин)-д даалгасугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Сайхан сумын Засаг дарга (Д.Сансар-Очир)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт), Сайхан сумын санхүү албаны дарга (М.Мөнхтөр) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010499

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 21-ны нийгмийн өдрийн А/380 дугаар
захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	2 778 656	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	2 778 656	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	1 389 328	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	5 000 000	Ү.Бямбасүрэн
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Ажлын 28 хоног	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн